



ХУШААТ СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2020 07 30 № 07А-2020/04-НА-15
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хушаат сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Хушаат сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хушаат сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Хушаат сумын Монгол Ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Хушаат сумын Монгол Ардын намын хорооны Хушаат сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хушаат сумын Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /...4..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Хушаат сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



СЭЛЭНГЭ АЙМАГ. ХУШААТ СУМ
МОНГОЛ АРДЫН НАМ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХУШААТ СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНЫ 2020 ОНЫ ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020 ОН



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХУШААТ СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Хушаат нутаг, Хушаатчуудын хөгжлийн төлөө хамтдаа



НЭГ.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.Боловсрол соёл,эрүүл мэнд

- 1.1.1 Иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэж цахимжуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 1.1.2 Эрүүл мэндийн даатгалын үр шимийг иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулна.
- 1.1.3 “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд”, “Эрүүл ирээдүй” хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн хоолойн архаг (ангина) өвчнийг эрт илрүүлэх зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 1.1.4 “Эрүүл чийрэг эр хүн” үндэсний хөтөлбөрийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- 1.1.5 Эмэгтэйчүүдэд товлолт дархлаажуулалт хийлгэж, умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх, хөхний эрүүл мэндийг хамгаалах болон “Энх бүсгүй” хөтөлбөрийг холбогдох байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.
- 1.1.6 Эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй хүнсний (чихэрлэг болон хийжүүлсэн ундаа, транс тос) талаарх “Хүнсний аюулгүй байдал”-ын сургалт, сурталчилгааг зохион байгуулж ажиллана.
- 1.1.7 Хувь хүн, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажилтан, сурагчид багш нартай ажиллах сэтгэл зүйчийг ерөнхий боловсролын сургууль дээр байнга ажиллах орчныг бүрдүүлнэ.
- 1.1.8 Биеийн тамир, спортод хөрөнгө оруулалт хийсэн хувь хүн, аж ахуйн нэгжид дэмжиж ажиллана
- 1.1.9 Хичээлээс гадуурх сургалтын хөтөлбөр боловсруулж, сонирхол, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.
- 1.1.10 Ахмадын амралт, сувиллын хөнгөлөлт, хүнсний талон зэрэг тусламж үйлчилгээний зардлыг хувь хүний тэтгэврийн дансанд шилжүүлдэг болгох боломжийг судалж, холбогдох шатны байгууллагад уламжилна.
- 1.1.11 Сумын эрүүл мэндийн төвийн барилгын их засварыг “Өвсний үндэс” хөтөлбөрийн санхүүжилтээр шийдвэрлүүлнэ.

2.Өрхийн хөгжил

- 1.2.1 Сумын хэмжээнд жил бүр 20-30 ажлын байр бий болгоно.
- 1.2.2 Залуу гэр бүлийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн "Залуу гэр бүл" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.2.3 Хүн амын өсөлтийн бодлогын хүрээнд гурав ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлд “Тогтвортой амар амгалан гэр бүл” хөтөлбөр хэрэгжүүлж, төсөл хөтөлбөрт хамруулахад дэмжлэг үзүүлж ажиллана.
- 1.2.4 Бага, дунд орлоготой иргэдийг дэмжих хуримтлалын санг иргэдийн оролцоо, хяналттайгаар бий болгож бага хүүтэй зээл олгоно.



- 1.2.5 Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах "Цахим карт" олгоно.
- 1.2.6 Суманд шинээр гэр бүл болж байгаа өрхүүдэд анх удаа орон сууц, байшин барихад шаардлагатай мод, модон материал бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.2.7 Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж, хяналтыг сайжруулна.
- 1.2.8 Ажил хөдөлмөр эрхэлдэг хүмүүст хувиараа хөдөлмөрлөх, аж ахуй эрхлэхийг дэмжиж ажиллана.
- 1.2.9 "Ахмадын сургаал алт" урианы дор залуу гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 1.2.10 Хушаат сумын төвд мах сүү, төмс, хүнсний ногоо, цагаан идээ борлуулах "Хушаатад үйлдвэрлэв" худалдааны төв байгуулна.



ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Газар тариалан, мал аж ахуйн бодлого

- 2.1 "Атрын IV аян" зохион байгуулж усалгаатай тариалан эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудыг дэмжиж ажиллана.
- 2.2 "Сэлэнгэ V" сортын төмсний үрийг үйлдвэрлэж, нутгийн тариалан эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдэд тариалж, нутагшуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 2.3 Орон нутгийн түүхий эдэд тулгуурласан цардуулын үйлдвэр байгуулах талаарх тооцоо, судалгаа хийж, холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 2.4 Малын тэжээлийн таримлыг сэлгээнд оруулж мал аж ахуйн тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.
- 2.5 Малчид тариаланчдын залгамж халааг бэлтгэх "Хушаат илгээлтийн эзэн III" аяныг сумын онцлогт тохируулан хэрэгжүүлнэ.
- 2.6 Малын гоц халдварт өвчингүй сум болох зорилтыг хэрэгжүүлнэ.
- 2.7 Суманд өсгөн үржүүлж буй казакын цагаан толгой үүлдрийн үхэр, баяд омгийн хонины бааз сууринд түшиглэн үхэр, хонь бордох бордооны цэг байгуулах талаар гаргасан иргэд аж ахуйн нэгжүүдийн санал, санаачилгыг дэмжиж ажиллана.
- 2.8 "Хушаат малчин" хөтөлбөр боловсруулан эрчимжсэн мал аж ахуй эрхлэх сургалт зохион байгуулж, малчдыг холбогдох төсөл, хөтөлбөрт хамрагдахад дэмжлэг үзүүлж ажиллана.
- 2.9 Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг ногоон тэжээл тариалах, боломжит хувилбаруудаас сонгон тэжээл тариалах, тэжээл үйлдвэрлэх цех байгуулах талаар гаргасан аж ахуйн нэгж, иргэдийн санал санаачилгыг тэргүүн ээлжинд дэмжинэ.



ГУРАВ.ДЭД БҮТЭЦ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО

1 Ногоон хөгжил

- 3.1.1 Цаг агаарын хувьсан өөрчлөгдөж буй нөхцөл байдалтай уялдуулан хөрсийг салхины элэгдлээс хамгаалах зорилгоор тариалангийн талбайд ойн зурвас байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

- 3.1.2 Ардын Хувьсгалын 100 жилийн ойг угтаж “Ногоон Хушаат” болох зорилт дэвшүүлэн сумын төвийн айл өрх бүрд 10-аас доошгүй мод тарих хөдөлгөөн өрнүүлж түүнийг дэмжиж ажиллана.
- 3.1.3 “Хашаандаа сайхан амьдаръя” уриалга гаргаж иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан санал, санаачилгыг дэмжиж ажиллана.
- 3.1.4 Бэлчээрийн доройтол, цөлжилтөөс хамгаалах зорилгоор суманд “Малчдын дундын сан” байгуулж бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх ажилд малчдын санаачилга хяналтын дор зарцуулна.
- 3.1.5 Сумын төвийн ногоон байгууламжийн эзлэх талбайн хэмжээг иргэд, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор 15 хувьд хүргэх ажлыг зохион байгуулна.
- 3.1.6 Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд халгүй аргаар тэмцэж, шаардагдах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 3.1.7 Сумын төвийн хөрс, ундны ус, агаарын бохирдлын хяналт, шинжилгээ болон хог хаягдлын менежментийг сайжруулна.
- 3.1.8 Рашаан булгийн урсац бүрэлдэх эхийг хамгаалж, цэвэрлэн орон нутгийн тусгай хамгаалалтад авна.

2. Аялал жуулчлалын бодлого


- 3.2.1 “Эртний түүхт - Хушаат нутаг” усан аялал, морин аялал, орон нутагтайгаа танилцах аяллын замын зураглал гаргаж сурталчилж ажиллана.

3. Дэд бүтцийн бодлого

- 3.3.1 Дархан-Сэлэнгийн төв замаас Хушаат сумын төв хүртэлх 20 км хатуу хучилттай зам барих ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 3.3.2 Сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, шинээр барих ажлыг хийнэ.
- 3.3.3 Сумын төвийн төр, төсвийн байгууллагуудыг төвлөрсөн дулаан хангамж, цэвэр усаар хангах, гэр хорооллыг инженерийн дэд бүтцэд холбох ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийж хологдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 3.3.4 Суманд “Орон сууцжуулах хөтөлбөр” зохион байгуулж түрээсийн орон сууцны барих аж ахуйн нэгж байгууллагуудын санал, санаачилгыг дэмжиж ажиллана.
- 3.3.5 Сумын төвд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Соёл, спортын барих ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 3.3.6 Рашаант хорооллын 35/04-н дэд станц, 22.5 км шугам сүлжээний ажил хийх ажлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.



ДӨРӨВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО



- 4.1 Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлтийг шуурхай шийдэж тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахим хэлбэрээр хянадаг болно.
- 4.2 Хүнд сурталгүй төрийн үйлчилгээ нэвтрүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын үйлчилгээг сайжруулж, төрийн албан хаагчдыг чадавхжуулж, төсвийн зардлыг хэмнэнэ.
- 4.3 Төсөв санхүүгийн хариуцлагын тогтолцоог бүрдүүлж, төсвийн хөрөнгийг нийгэм, эдийн засгийн хөгжилд оновчтой, үр ашигтай зарцуулахад иргэд, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлнэ.
- 4.4 Аялал жуулчлал, рашаан сувиллыг хөгжүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэхэд анхаарч, хөрөнгө оруулагчдыг дэмжин хамтарч ажиллана.
- 4.5 Татварын шинэ хуулийг хэрэгжүүлэх, төсвийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

ХУШААТ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

